



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/85

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 28, 29, 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 67 тоот тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 12 дахь хэсгийн заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын хамтарсан магадлал зохион байгуулах заавар”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дахин магадлал зохион байгуулах заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс /П.Мөнхтулга/-г, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дэд дарга /Г.Саран/-д тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны А/160 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын бүрдмэл магадлал зохион байгуулах заавар”, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын даргын батласан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дахин магадлал зохион байгуулах заавар”-уудыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ЗОРИГТ

015110000



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ ТӨВ
КОМИССЫН ХАМТАРСАН БОЛОН ДАХИН МАГАДЛАЛ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

Баримт бичгийн дугаар: ЗВР-ЭХМТК-01-2021

Баталсан:

НДЕГ-ын дарга

Д.ЗОРИГТ

Хянасан:

ЭХМТК-ын дарга

П.МӨНХТУЛГА

Боловсруулсан:

ЭХМТК-ын магадлагч эмч

Д.АНХБАЯР

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	



Баримт бичгийн үндсэн мэдээлэл

Баримт бичгийн хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
НДЕГ-ын ЭХМТК		2021 он	2021 он	4

Нэмэлт өөрчлөлтийн тухай тэмдэглэл


Нэмэлт өөрчлөлт	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1	2017	Өөрчлөн найруулсан	М.Нармандах
Хувилбар 2	2021	Шинэчлэн боловсруулсан	Д.Анхбаяр
Хувилбар 3			
Хувилбар 4			
Хувилбар 5			
Хувилбар 6			





АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл
2. Хамтарсан магадлалын хэлбэр, бүрэлдэхүүн
3. Хамтарсан магадлалын үе шат
4. Хамтарсан магадлалын баталгаажилт
5. Бусад





Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2021 оны 06 сарын 18-ны өдрийн
А/SS дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ ТӨВ КОМИССЫН ХАМТАРСАН МАГАДЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс /цаашид “Төв комисс” гэх/ нь шинжээч эмч болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран даатгуулагч (иргэн)-дад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлэсэн байдалд хяналт шалгалт хийхийг “Хамтарсан магадлал” гэнэ.

1.2.Хамтарсан магадлалыг Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм” болон холбогдох бусад хууль, эрх зүйн бичиг баримтын хүрээнд зохион байгуулна.

1.3.Хөдөлмөрийн чадвар алдалтын байдал, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн сангийн үзүүлэлт, судалгаа шинжилгээний дүн, дүгнэлт болон холбогдох байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл гомдол зэрэгт үндэслэн хамтарсан магадлалд хамрагдах аймаг (дүүрэг)-ийг сонгоно.

1.4.Хамтарсан магадлалыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус байдлаар зохион байгуулна.

1.5.Хамтарсан магадлалын удирдамж, төсвийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга батлана.

Хоёр. Хамтарсан магадлалын хэлбэр, бүрэлдэхүүн

2.1.Хамтарсан магадлалыг дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

- иргэдийг байлцуулан үзлэг оношилгоо, шинжилгээнд хамруулан магадлах;
- иргэдийн эрүүл мэндийн баримт бичигт тулгуурлан магадлах;

2.2.Хамтарсан магадлалд тухайн орон нутгийн хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн 25-с доошгүй хувийг хамруулна.

2.3.Төв комисс нь төлөвлөгөөт хамтарсан магадлал зохион байгуулах хуваарийг үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгаж батална.



2.4.Төв комисс нь төлөвлөгөөт бус хамтарсан магадлалыг холбогдох байгууллагаас ирүүлсэн санал болон төв комиссын шийдвэр, байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл гомдлыг үндэслэн зохион байгуулна.

2.5.Хамтарсан магадлалыг Төв комиссын дарга эсхүл нарийн бичгийн дарга ахалж ажиллана.

2.6.Хамтарсан магадлалын бүрэлдэхүүнд ажиллах төрөлжсөн мэргэжлийн эмчийг тухайн орон нутгийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, өвчлөлийн байдал зэргээс хамааран сонгоно.

2.7.Хамтарсан магадлалын бүрэлдэхүүнд ажиллах гишүүдийн тоог тус зааврын 2.4-т заасан шалтгаанаас хамааран тогтооно.

2.8. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авч зөвшилцсөний үндсэн дээр хамтарсан магадлалын бүрэлдэхүүнд ажиллах төрөлжсөн мэргэжлийн эмчийг томилох бөгөөд зайлшгүй шалтгааны улмаас бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тохиолдолд хамтарсан магадлал зохион байгуулах хугацаанаас 10 хоногийн өмнө орлох эмч мэргэжилтний нэрсийг Төв комисст ирүүлнэ.

2.9.Хамтарсан магадлалын бүрэлдэхүүн шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллаж болно.

2.10.Хамтарсан магадлалд оролцсон нийт гишүүдэд хуралдаж ажилласан цагийн хөлсийг “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-д заасны дагуу тооцож олгоно.


Гурав.Хамтарсан магадлалын үе шат

3.1.Бэлтгэл үе

3.1.1.Төв комисс нь эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн сангаас хамтарсан магадлалд хамруулах иргэдийг түүвэрлэлтийн аргаар сонгон 21 хоногийн өмнө салбар болон орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст илгээнэ.

3.1.2.Салбар болон орон нутгийн комисс дараах бэлтгэл ажлыг хариуцна. Үүнд:

- хамтарсан магадлалын удирдамжийг орон нутгийн удирдлага болон холбогдох байгууллагуудад танилцуулах;
- үзлэгийн хуваарь гаргах;
- үзлэгийн өрөө бэлтгэх;
- шаардлагатай шинжилгээ оношилгооны тоног төхөөрөмжөөр хангах;
- шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнийг ажиллуулах;
- зохион байгуулалтын бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.





3.2.Хамтарсан магадлал хийх үе

3.2.1.Хамтарсан магадлалыг ахалж буй албан тушаалтан нь удирдамжийг танилцуулан ажлын зааварчилгаа өгнө.

3.2.2.Төв комиссын магадлагч эмч нь бэлтгэл ажлыг нягтлан шалгана.

3.2.3.Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч (иргэн)-ийн эмчилгээ, шинжилгээ, оношилгоо, эмчлэгч эмчийн дүгнэлт, эмнэлэг хяналтын комиссын шийдвэр, сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн байдал зэргийг үндэслэн магадлана.

3.2.4.Шаардлагатай тохиолдолд оношийн үндэслэлийг баталгаажуулах зорилгоор оношилгоо, шинжилгээнд хамруулж болно.

3.2.5.Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг “хэвээр” сунгах тохиолдолд салбар болон орон нутгийн комиссын өмнөх шийдвэрийн хугацаанаас үргэлжлүүлэн сунгана.

3.2.6.Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг “өөрчлөн сунгах”, “цуцлах” тохиолдолд салбар болон орон нутгийн комиссын өмнөх шийдвэрийг хүчингүй болгож, хамтарсан магадлал хийсэн өдрөөс эхлэн тооцно.

3.2.7.Өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тухайн орон нутагт нь цахимаар шийдвэрлэнэ.

3.2.8.Тухайн орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нарийн бичгийн дарга нь хамтарсан магадлалд хамрагдсан даатгуулагч (иргэн)-ийг эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн санд бүртгэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоосон болон цуцалсан шийдвэрийн хуудас хэвлэн, хамтарсан магадлалын хурлын тэмдэглэлийг хөтөлнө.


3.2.9.Салбар болон орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмч нараас тайлбар, лавлагаа мэдээлэл авч, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгнө.

3.2.10.Төв комисс болон Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд ажлын байрны сургалт зохион байгуулна.

3.3.Хамтарсан магадлалын баталгаажилтын үе

3.3.1.Хамтарсан магадлалын бүрэлдэхүүн нь даатгуулагч (иргэн)-д хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон шийдвэрт гарын үсэг зурж, Төв комиссын тэмдэг дарж баталгаажуулна.

3.3.2.Хамтарсан магадлалд хамрагдаагүй даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг Төв комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд баримт бичиг үндэслэн цахимаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэнэ.





3.3.3.Төв комисс нь хамтарсан магадлалд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хамрагдаагүй даатгуулагч (иргэн)-ийн тахир дутуугийн тэтгэврийг түр түдгэлзүүлэх саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргад хүргүүлнэ.

Дөрөв. Бусад


4.1.Хамтарсан магадлалыг зохион байгуулсан тухай тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлагад танилцуулж холбогдох арга хэмжээг авна.

4.2.Салбар болон орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь хамтарсан магадлалын шийдвэрээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа цуцлагдсан даатгуулагч (иргэн)-д хөдөлмөрийн чадвар алдалт дахин тогтоохдоо Төв комиссын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

4.3.Иргэдийг хамтарсан магадлалд хангалтгүй хамруулсан, бэлтгэл ажлыг хангаагүй бол Нийгмийн даатгалын хэлтсийн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллана.

4.4.Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг үндэслэлгүйгээр шийдвэрлэсэн, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн санд засвар хийсэн бусад холбогдох дүрэм журмыг зөрчсөн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, болон холбогдох эмч мэргэжилтнүүдэд хариуцлага тооцно.

4.5.Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоолгох, сунгуулах зорилгоор комиссын гишүүдэд хууль бусаар нөлөөлсөн албан тушаалтан, аливаа этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна.






Баримт бичгийн үндсэн мэдээлэл

Баримт бичгийн хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
НДЕГ-ын ЭХМТК		2021 он	2021 он	3

Нэмэлт өөрчлөлтийн тухай тэмдэглэл

Нэмэлт өөрчлөлт	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1	2018	Шинэчлэн боловсруулсан	А.Удвалцэцэг
Хувилбар 2	2021	Өөрчлөн найруулсан	Д.Анхбаяр
Хувилбар 3			
Хувилбар 4			
Хувилбар 5			
Хувилбар 6			





АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл
2. Дахин магадлалын хэлбэр, бүрэлдэхүүн
3. Дахин магадлалын үйл ажиллагаа
4. Бусад





Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2021 оны 06 сарын 22-ны өдрийн
А/6.5 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ ТӨВ КОМИССЫН ДАХИН МАГАДЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс (цаашид “Төв комисс” гэх)-оос салбар болон орон нутгийн комиссын үйл ажиллагаа, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэсэн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийхийг “Дахин магадлал” гэнэ.

1.2. Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм” болон холбогдох бусад хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд дахин магадлалыг зохион байгуулна.

1.3. Дахин магадлалын удирдамж, төсвийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга батална.

Хоёр. Дахин магадлалын хэлбэр, бүрэлдэхүүн

2.1. Дахин магадлалыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр зохион байгуулна.

2.2. Төлөвлөгөөт дахин магадлалыг Төв комиссын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу зохион байгуулна.

2.3. Төлөвлөгөөт бус дахин магадлалыг холбогдох байгууллагаас ирүүлсэн санал болон Төв комиссын шийдвэр, байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл гомдлыг үндэслэн зохион байгуулна.

2.4. Дахин магадлалд аймаг (дүүрэг)-ийн Нийгмийн даатгалын хэлтэс, төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, өрх (сум)-ийн эрүүл мэндийн төв, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний сувилал зэрэг байгууллагыг хамруулан шалгана.

2.5. Дахин магадлалыг Төв комиссын гишүүд хийж гүйцэтгэх ба Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөл болон мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг (зөвшилцсөнөөр) оролцуулан хамтарсан байдлаар зохион байгуулж болно.

Гурав. Дахин магадлалын үйл ажиллагаа

3.1. Салбар болон орон нутгийн комисс дараах бэлтгэл ажлыг хариуцна. Үүнд:



3.1.1. Дахин магадлалд хамрагдах даатгуулагч (иргэн)-ийн эрүүл мэндийн баримт бичиг, оношилгоо шинжилгээний дүгнэлт, холбогдох бусад баримт бичгүүдийг бэлтгэсэн байх;

3.1.2. шаардлагатай шинжилгээ оношилгооны тоног төхөөрөмжөөр хангах;

3.1.3. зохион байгуулалтын бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3.2. Дахин магадлалын бүрэлдэхүүн нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

3.2.1. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон нийт даатгуулагч (иргэн)-ийн 30 хувийг дахин магадлалд хамруулан, эмнэлгийн хувийн хэрэг, амбулаторийн карт, холбогдох баримт бичгийг шалган шаардлагатай тохиолдолд иргэнийг байлцуулан хяналт шалгалт хийх;

3.2.2. Тэтгэврийн нийт хувийн хэргийн 30 хүртлэх хувийг шалган, эмнэлгийн анхан шатны баримт бичиг, амбулаторийн карт дахь эмчийн үзлэг, оношилгоо, оношийн баталгаажилт, сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдсан байдалд дүн шинжилгээ хийх;

3.2.3. Шаардлагатай тохиолдолд төрөлжсөн мэргэжлийн эмч нартай хамтарсан бодит үзлэг хийн, оношилгоо шинжилгээнд хамруулах;

3.2.4. Нийгмийн даатгалын байгууллагаас сүүлийн 2 жилд хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан даатгуулагчдын 20 хүртлэх хувийг хамруулан тэтгэмж олголтын үндэслэлийг шалгах;


3.2.5. Эрүүл мэндийн байгууллагаас сүүлийн 2 жилд олгосон эмнэлгийн хуудасны 20 хүртлэх хувийг хамруулан эмнэлгийн хуудас олголтын үндэслэлийг шалгах (шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн байгууллагын анхан шатны бүртгэл, өвчний болон төрөлтийн түүх, өдрийн эмчилгээний түүх, амбулаторийн картын бичилттэй тулгах);

3.2.6. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй сувиллын бүтэц үйл ажиллагааны стандарт болон холбогдох хууль тогтоомж, журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг шалгах;

3.2.7. Салбар болон орон нутгийн комиссын мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд хяналт шалгалт хийх;

3.2.8. Эмнэлэг хяналтын комисс, салбар болон орон нутгийн комиссын хурлын явцтай танилцаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

3.2.9. Дахин магадлал зохион байгуулах хугацаанд тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын эмч нарт сургалт зохион байгуулах;





Дөрөв. Бусад

4.1. Дахин магадлал зохион байгуулсан талаарх урьдчилсан дүнг салбар болон орон нутгийн комисст танилцуулна.

4.2. Дахин магадлалын тайлан, цаашид авах арга хэмжээний саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллана.

4.3. Дахин магадлалын зорилго, зохион байгуулах хугацаа, бүрэлдэхүүн зэргээс хамаарч тус зааврын 3.2-т заасан ажлуудаас сонгон удирдамжид тусган зохион байгуулж болно.

4.4. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг үндэслэлгүйгээр шийдвэрлэсэн, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн санд засвар хийсэн, эмнэлгийн хуудсыг хуурамчаар бичсэн, сувиллын гэрээ, бусад холбогдох дүрэм журмыг зөрчсөн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, сувиллын болон холбогдох эмч мэргэжилтнүүдэд хариуцлага тооцно.

4.5. Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоолгох, сунгуулах зорилгоор комиссын гишүүдэд хууль бусаар нөлөөлсөн албан тушаалтан, аливаа этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна.

